



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн
алба ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийг
балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журмын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлтийн дансанд бүртгэлтэй нийт 485,700,100.00 (дөрвөн зуун наян таван сая долоон зуун мянга нэг зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Налайх дүүргийн Спортын хорооны баланст шилжүүлсүгэй.

2.Тус хавсралтад заасан хөрөнгийг данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ (О.Уранчимэг), шилжин ирсэн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан бүртгэж авахыг Налайх дүүргийн Спортын хороо (Д.Мөнхбаяр)-нд тус тус даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ (О.Уранчимэг), Налайх дүүргийн Спортын хороо (Д.Мөнхбаяр)-нд тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

1150500029

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн
А.ф..... дугаар тушаалын хавсралт

1/30

Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ-т

№	Эд хогшлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Тартам зам	ш	1	2015	485,700,100.00	485,700,100.00			Налайх дүүргийн спорт хороо
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн					485,700,100.00	485,700,100.00	-		